2021 ОНЫ 4-Р САР

# ЕРӨНХИЙ ЧУУЛГАНД ЗОРИУЛСАН **ТЭМДЭГЛЭЛИЙН ДЭВТЭР**

**ЕРӨНХИЙ ЧУУЛГАНААС
ОЛЖ АВСАН ОЙЛГОЛТ,
ХУВИЙН ИЛЧЛЭЛТЭЭ
ТЭМДЭГЛЭХ ХЭСЭГ**

# Сүнсний өдөөлт ЭНДЭЭС ЭХЭЛНЭ.

Ерөнхий чуулган бол Их Эзэн чамд шууд хандан ярих гайхалтай сайхан завшаан юм. Их Эзэний үйлчлэгчид ярих үед Ариун Сүнс Есүс Христийг гэрчилдэг (Иохан 15:26-г үзнэ үү) бөгөөд “чиний хийх бүх зүйлийг” заах болно (2 Нифай 32:3). Үг хэлэгч юу хэлэхийг чи залбирч тунгаан, чин сэтгэлээсээ сонсох үед Их Эзэн чамд зориулсан хувийн илчлэлтийг өгч чадна гээд чи төсөөлөөд үздээ. Их Эзэн чамайг мэдээсэй мөн хийгээсэй гэж хүсдэг зүйлээ чамд хэлэх болно. Доорх будуувч үүнийг тайлбарлах болно:

**ТИЙМЭЭС, ОДОО #ТҮҮНИЙГСОНСОХ-ДОО БЭЛТГЭЖ ЭХЭЛ.**

- Ариун Сүнс чамд сүнслэг өдөөлт өгөхийн төлөө залбир.
- Өөрт байгаа бүх асуултыг бичиж ав.
- Ерөнхий чуулганаас аль болох боломжоороо уншиж, сонсох төлөвлөгөө гарга.



**ҮГ ХЭЛЭГЧ БҮРИЙГ СОНСОХ БҮРДЭЭ “ИХ ЭЗЭНИЙ ДУУ ХООЛОЙ” ЯРЬЖ БАЙГАА МЭТ СОНС**
(Сургаал ба Гэрээ 68:3-4-ыг үзнэ үү).



**АРИУН СҮНС ТАНЫ ЗҮРХ СЭТГЭЛ, ОЮУН БОДОЛД ХАНДАН ЯРИХ БОЛНО**
(Сургаал ба Гэрээ 8:2-3-ыг үзнэ үү).

**ХҮЛЭЭН АВСАН МЭДРЭМЖЭЭ БИЧИЖ ТЭМДЭГЛЭ**
(2 Нифай 29:11-ийг үзнэ үү).



**СУРСАН, МЭДЭРСЭН ЗҮЙЛИЙНХЭЭ ДАГУУ ҮЙЛД**
(Иохан 7:17; 1 Нифай 3:7-г үзнэ үү).

# Бямба гаргийн ӨГЛӨӨНИЙ ХУРАЛДААН

Их Эзэн үг хэлэгч бүрийг хуваалцаасай гэж хүссэн тодорхой захиасуудаараа өдөөсөн байсан. Түүнчлэн Тэр зөвхөн чамд зориулсан захиасыг Ариун Сүнсээр дамжуулж өгөх болно. Ерөнхий чуулганд оролцох үедээ аль алийг нь сонс.

**ӨНӨӨДӨР БИ ЕСҮС ХРИСТИЙН ТАЛААР ЮУ СУРСАН БЭ?**

Их Эзэн надад заахыг хичээж байгаа зүйлийн талаар би юу мэдэрч байна вэ?

**ЭНЭ БОЛОН БҮХ ЦАГ ҮЕИЙН ЕРӨНХИЙ ЧУУЛГАНЫ ЗОРИЛГО БОЛ ТҮҮНИЙГ СОНСОХОД БИДЭНД ТУСЛАХ ЯВДАЛ ЮМ.**

Ерөнхийлөгч Рассэлл М.Нэлсон[1]

Ямар захиас нь онцгой санагдсан бэ? Яагаад?



Би одоо юу хийх вэ?

# Бямба гаргийн **ҮДЭЭС ХОЙШИХ ХУРАЛДААН**

Ерөнхий чуулганаас хүлээн авсан мэдрэмжээ бичиж авахдаа чи Их Эзэнээр заалгахыг хүсэж буй өөрийн хүслээ харуулж байдаг. Чи Түүний заасны дагуу үйлдсэнээр Түүнтэй илүү адилхан болох болно.

**АВРАГЧИД ИЛҮҮ ОЙРТОХЫН ТУЛД ЮУ ХИЙХ ХЭРЭГТЭЙ ГЭСЭН МЭДРЭМЖ НАДАД ТӨРЖ БАЙНА ВЭ?**

# Бямба гаргийн **ОРОЙН ХУРАЛДААН**

Ерөнхий чуулганд оролцож байх үед Ариун Сүнс чамд заахын төлөө залбир. Тэрээр зөвхөн чамд зориулсан гүнзгий ойлголтыг өгөх болно. Эдгээр ойлголт, сэтгэгдлээ бичиж, хэрэгжүүлэх төлөвлөгөө гарга.

## ЕСҮС ХРИСТТЭЙ ИЛҮҮ АДИЛХАН БОЛОХОД ТУСЛАХ ЮУ ХИЙХЭД НАМАЙГ УРЬСАН БЭ?



***ХЭЛЭГДЭЖ* БУЙ ЗҮЙЛС НЬ БИДНИЙ *СОНСОЖ, МЭДЭРЧ* БАЙГАА ЗҮЙЛТЭЙ АДИЛ ЧУХАЛ БАЙДАГГҮЙ.**

Ахлагч Робэрт Д.Хэйлс[2]

# Ням гаргийн ӨГЛӨӨНИЙ ХУРАЛДААН

Ерөнхий чуулганы захиасуудыг уншиж, сонсох үедээ хүлээн авсан сүнслэг мэдрэмжээ тэмдэглэн ав. Ямар ямар үнэн заагдаж байна вэ? Юу нь чамд хамгийн чухал вэ?

**ЭНЭ ХУРАЛДААНЫ ТУРШ АВРАГЧИЙН ХАЙРЫГ БИ ХЭРХЭН МЭДЭРСЭН БЭ?**







**“АМЬДРАЛЫГ ТОДОРХОЙЛОГЧ СҮНСЛЭГ ЦАГ МӨЧ БИДНИЙГ ЕРӨНХИЙ ЧУУЛГАНЫГ ЗАЛБИРЧ СОНСОХОД МӨН ЗАРЛИГУУДЫГ ИЛҮҮ САЙН ДАГАХ ҮЕД ИРДЭГ.”**

Ахлагч Нийл Л.Андэрсэн[3]

# Ням гаргийн **ҮДЭЭС ХОЙШИХ ХУРАЛДААН**

Үг хэлэгч бүрийн зааж буй захиасыг сонсох нь чухал. Ариун Сүнсний чамд заахыг хичээж буй захиасыг сонсох нь үүнтэй ижил тэгш чухал юм.

## ЕСҮС ХРИСТИЙН ЦАГААТГАЛЫН ТАЛААР БИ ЮУ СУРСАН БЭ?

**"БИДЭНД ХАНДАЖ ҮГ ХЭЛЭХ ХҮМҮҮС ЗАХИАСАА БЭЛТГЭХДЭЭ ТЭНГЭРЛЭГ ТУСЛАМЖ БА УДИРДАМЖИЙГ ЭРЭЛХИЙЛСЭН БАЙГАА. . . . ИНГЭСНЭЭР БИД ЭНЭ ЧУУЛГАН ДЭЭР ХЭЛЭГДЭХ ҮГСИЙГ СОНСОЖ, ТҮҮНЭЭС СУРАЛЦАХДАА ИХ ЭЗЭНИЙ СҮНСЭЭР ДҮҮРЭН БАЙХ НЬ МИНИЙ ЗАЛБИРАЛ ЮМ."**

Ерөнхийлөгч Томас С.Монсон[4]

# Зугаатай **ЗОГСООЛ**

### Чи тохируулж чадах уу?

Доорх нь судар дахь хос багцууд юм. Эдгээр шүлгийг ашиглан зүүн талд байгаа зүйлсийг баруун талд байгаа зүйлстэй тохируул.

- Сургаал ба Гэрээ 20:77, 79
- Алма 32:26-30
- Иохан 10:14-15
- 1 Самуел 17:38-40, 46-50
- Марк 6:34–44



### Танграм Сорилт

Танграм нь Хятадын эртний оньсон тоглоом юм. Зүүн талд байх дүрсүүдийг хөдөлгөөд энэ харагдаж байгаа сахиусан тэнгэр Моронайн хөшөөний, лааны, тагтааны дүрсийг эвлүүлж чадах эсэхээ үз. Аль нэгийг нь эвлүүлж чадаж байна уу?







### Чуулгантай холбо

Чуулганд оролцох өөр өөр арга замыг төлөөлсөн утас бүрийг дага.

# Тэгэхээр, **ОДОО ЯАХ ВЭ?**

Ерөнхий чуулган дууссан байж болох ч сурч мэдсэн зүйлсийн чинь туршлага одоо л эхэлж байна. Сонсож мэдэрсэн зүйлсээ үйлдэхийн тулд чи юу хийх вэ? Чамд хийж хэрэгжүүлнэ гэсэн маш олон зүйл байж болох ч тэдгээрийг нэгэн зэрэг хийж чадахгүй. Дараагийн алхмаа төлөвлөхөд чинь туслах хэдэн асуулт байдаг.

1. Чи амьдралдаа юуг өөрчлөхөөр эсвэл үргэлжлүүлэн хийхээр өдөөгдсөн бэ?

2. Эдгээрийн аль нь одоо үйлдэхэд хамгийн чухал гэж чи бодож байна вэ?

3. Чи ямар ямар зорилго шинээр тавьж эсвэл дахин амлалт өгөн хийж болох вэ?

4. Хэнээс тусламж хүсэж болох вэ?

**ЭХ СУРВАЛЖ**

1. Рассэлл М.Нэлсон, “Нээлтийн захиас,” 2020 оны 4-р сарын Ерөнхий чуулган (*Ensign* эсвэл *Лиахона* 2020 оны 5-р сар).
2. Робэрт Д.Хэйлс, 2013 оны 10-р сарын Ерөнхий чуулган (*Ensign* эсвэл *Лиахона,* 2013 оны 11-р сар, 6).
3. Нийл Л.Андэрсэн, 2020 оны 4-р сарын ерөнхий чуулган (*Ensign,* эсвэл *Лиахона,* 2020 оны 5-р сар).
4. Томас С.Монсон, “Чуулганд тавтай морилно уу,” 2009 оны 10-р сарын ерөнхий чуулган (*Ensign* эсвэл *Лиахона,* 2009 оны 11-р сар, 6.
5. Рассэлл М.Баллард, 2020 оны 4-р сарын ерөнхий чуулган (*Ensign* эсвэл *Лиахона,* 2020 5-р сар, 11).

# ЧАМД ЗОРИУЛСАН СҮНСЛЭГ ӨДӨӨЛТ

**"АМРАЛТЫН ЭНЭ ӨДРҮҮДЭД СҮНСИЙГ СОНСОХДОО, ИРЭХ ӨДРҮҮДЭД ЗӨВ ШУДАРГААР ИХ ЭЗЭНД ЯМАР ӨРГӨЛ ӨГӨХӨӨ ЭРГЭЦҮҮЛЭН БОДОЦГООЁ. ЗОРИГТОЙ БАЙ. ИТГЭЖ НАЙДДАГ ХҮНТЭЙГЭЭ ХУВААЛЦ. ХАМГИЙН ГОЛ НЬ ҮҮНИЙГ ХИЙХ ЦАГ ЗАВ ГАРГААРАЙ!**

Ерөнхийлөгч М.Рассэлл Баллард[5]

## ӨӨР ХУВЬ ХЭРЭГТЭЙ ЮУ?

Энэхүү тэмдэглэлийг
**conference.ChurchofJesusChrist.org**
хаягаар татан авч хэвлэнэ үү.

© 2021 Intellectual Reserve, Inc. Бүх эрх хамгаалагдсан.

Уг товхимлыг дахин хэвлэх зөвшөөрөл нь хувийн болон арилжааны бус хэрэгцээнд зориулагдсан болно. Тойргийн удирдагчид өөрсдийн дуудлагын хүрээнд үйлчилж буй хүмүүстээ зориулан цөөн тоогоор хэвлэж болно. Уг товхимлыг бүхэлд нь хэвлэх ёстой. Энэхүү зөвшөөрөл нь уг материалыг интернэт орчинд байршуулах, өөр зорилгоор ашиглах, түгээхэд хамаарахгүй болно. Уг материалыг нэмэлт зорилгоор ашиглах бол зөвшөөрөл авах шаардлагатай.

**permissions.ChurchofJesusChrist.org**

ЕСҮС ХРИСТИЙН ХОЖМЫН ҮЕИЙН ГЭГЭЭНТНҮҮДИЙН СҮМ